

ДБҮЭГ-ЫН ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН МЭРГЭЖИЛТЭН Н.МӨНХТУУЛЫН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018 оны 11 сарын 23 өдөр

Улаанбаатар хот

“ДБҮЭГ” ТӨҮГ-ын дотоод хяналт шалгалтын үйл ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, газрын захирлын баталсан дүрэм журмын хүрээнд мөрдөн ажиллаа.

Ажлын байрны зорилго зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг явуулсан.

Төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл

Нэг. Хяналт шалгалтын чиглэлээр хийх нэгдүгээр зорилтын хүрээнд:

ДБҮЭГ-ын захирлын баталсан Дотоод хяналт шалгалтын журмын дагуу 2018 оны дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг гарган батлуулж, Автобааз, Зоог үйлчилгээ, “Дипломат” зочид буудлын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг явуулсан. Хяналт шалгалтын дүнг удирдлага болон ажилтнуудад танилцуулан, илэрсэн зөрчил дутагдалд санал зөвлөмжүүдийг өгсөн. Санал, зөвлөмжийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлын тайланг 2 дугаар улиралд нэгтгэн дүгнэж, захирлын зөвлөлийн хурлаар танилцуулсан.

“ДБҮЭГ” ТӨҮГ-ын 2018 онд батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай 27 бараа ажил, үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 100% цахимаар амжилттай явуулж, хяналт тавин ажиллаа.

“Дипломат” зочид буудлын өргөтгөл Татваргүй барааны дэлгүүрийн шугамын засварын ажил, Тээврийн хэрэгслийн даатгалын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер, “Чин ван Ханддоржийн өргөө” цогцолборын засварын ажил зэрэг тендерийн үнэлгээний хороонд нарийн бичгээр орж ажилласан.

Худалдан авах ажиллагаатай холбоотой шилэн дансны бүтэн жилээр, сар бүр, тухай бүрт оруулах мэдээллийг цаг тухайд нь оруулж, тайланг улирал бүр хугацаанд нь мэдээлсэн.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8,9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийн дагуу захирлыг гэрээ байгуулсан 27, тендерийн үнэлгээний хорооны гишүүдийн 81 мэдэгдлийг шилэн дансанд мэдээлсэн байна.

ДБҮЭГ-ын болон Захиргааны хэлтсийн 2017 оны ажлын гүйцэтгэл болон 2018 оны ажлын төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, удирдлагад танилцуулан батлуулсан. Мөн захиргааны хэлтсийн ажилчдын сарын ажлын төлөвлөгөө болон гүйцэтгэлийг нэгтгэн боловсруулж, хяналт шинжилгээ хийн удирдлагад танилцуулсан.

Сангийн яамны дотоод аудитын хорооны 16 дугаар тогтоол, ТӨБЗГ-ын А-1/350 дугаар албан даалгавар, Үндэсний аудитын газрын 2017 оны санхүүгийн тайланд өгсөн зөвлөмж, үүрэг даалгаврыг биелүүлэх төлөвлөгөөг гарган батлуулж, төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр мэдээлэн ажиллаа. ТӨБЗГ, Гадаад харилцааны яам болон бусад дээд шатны байгууллагуудаас ирсэн албан даалгавруудыг цаг хугацаанд нь биелүүлэн ажилласан.

Хоёр. Дотоод ажил

Бусад чиг үүргийн дагуу хэрэгжүүлсэн ажил:

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, газрын дүрэм журмын хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд “Өмч хамгаалах комисс”, “Ёс зүйн хороо”-нд орж ажиллаж байна.

Мөн дараах ажлын хэсгүүдэд орж, нарийн бичгээр ажилласан байна. Үүнд:

- “Чин ван Ханддоржийн өргөө” цогцолборыг “Скай виста” ХХК-аас хүлээн авах
- ДБҮЭГ-ын 12-р байрыг “Голден бридж ньу Монголия” ХХК-аас хүлээн авах
- ДБҮЭГ-ын 13-р байр буюу БНКУ-ын ЭСЯ-ны байрыг хүлээн авах
- ДБҮЭГ-ын 15-р байр-ыг түрээслэгч Үндэсний хүмүүнлэгийн хорооноос хүлээн авах
- Асем-ын өр барагдуулах ажлын хэсэг зэрэг болно.

ТӨБЗГ-ын 2018 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолоор “Төрийн өмчит хуулийн этгээдийн “Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам”-ыг баталсантай холбогдуулан газрын Өмч хамгаалах зөвлөлийг шинэчлэн батлуулж, Өмч хамгаалах зөвлөлийн 2018 оны 2 дугаар хагас жилийн ажлын төлөвлөгөөг хуулийн зөвлөлтэй хамтран гаргаж, мөрдөн ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн Газраас 2018 оныг Сахилга хариуцлага, дэг журмыг сайжруулах жил болгон зарласантай холбоотой 32 дугаар тогтоол, 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 258 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлэх, байгууллагын үйл ажиллагаа, хамт олны уур амьсгал, бүтээмжийг сайжруулах зорилгоор газрын захиралтай хамтран “Бид бүтээлч хамт олон” уралдааны удирдамжийг боловсруулан, 2 сарын турш уралдааныг явуулж, дүгнэн шалгаруулсан.

Өөрийн мэдлэг, мэргэшил, ур чадвараа дээшлүүлэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх СУУРЬ МЭДЛЭГ ОЛГОХ сургалтад хамрагдаж, гэрчилгээ гардан авсан. “МУ-ын мэргэшсэн дотоод хяналтын аудитор” эрх олгох хөтөлбөрийн багц сургалтад хамрагдан, амжилттай төгссөн.

Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам болон дотоод хяналт шалгалтын журамд заасан ажилтны хүлээх эрх үүргийг хариуцлагатайгаар биелүүлэн ажилласан болно.

